

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГТЭЙ ТАНИЛЦСАН:
“ХЭРЭМТ ЦАМХАГ” УТҮГ-ЫН ЗАХИРАЛ
ХУРАНДАА Н.МӨНХЖАРГАЛ

ШАТАХУУН ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: Шатахуун
Тендер шалгаруулалтын дугаар: Хэрэмт Цамхаг УТҮГ/202002009

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

НЭГ: ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: ШШГЕГ-ын харьяа “Хэрэмт цамхаг” УТҮГ-т Шатахуун
нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.
Тендер шалгаруулалтын дугаар: “Хэрэмт цамхаг- УТҮГ /202002009

“Хэрэмт цамхаг” УТҮГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос 1320 литр шатахуун нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн нэг жилийн борлуулалтын орлого нь тендерт санал болгох үнийн дүнгийн 100%-с багагүй байх.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан: Сүүлийн нэг жил /2019 оны аудитын дүгнэлтийн хамт ирүүлнэ үү. Санхүүгийн тайлан e-balance цахим бүртгэлд шивэгдсэн байх.

Үнийн саналыг 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 12 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны WWW.TENDER.GOV.MN цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын албан конторын хурлын танхимд 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 12 цаг 30 минутанд цахимаар нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

421 дүгээр нээлттэй хорих ангиын хашаанд “Хэрэмт цамхаг” УТҮГ санхүүгийн өрөө
Б.Лхагвадулам 99189408, 89189944

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа

1.1 Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт

2.1 Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2 Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

3. Тендерийн иж бүрдэл

3.1 Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- (а) Үнийн санал;
- (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
- (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
- (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
- (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]

4. Тогтмол үнэ

4.1 Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд

5.1 Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2 Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа

6.1 Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх

7.1 Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2 Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3 Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

8.1 Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн 1 жил буюу 2019 оны санхүүгийн тайлан ирүүлнэ.</p> <p>Сүүлийн 1 жил буюу 2019 онд ижил төстэй бараа нийлүүлж байсан туршлагын мэдээлэл ирүүлэх. Ижил төстэй бараа гэдэгт тухайн багцад хамаарах барааг ойлгоно. /Гэрээ гэрээ дүгнэсэн актын хуулбарыг ирүүлнэ/</p> <p>Тендерт оролцогч дараах материалуудыг бэлтгэн ирүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> - Байгууллагын товч танилцуулга - Улсын бүртгэлийн гэрчилгээ. - Бараа нийлүүлэлтийн хуваарь маягтын дагуу баталгаажуулан ирүүлэх. - Барааны үнийн хуваарыг маягтын дагуу баталгаажуулан ирүүлнэ. - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны өр төлбөргүй тухай тодорхойлолт. - Барааг нийлүүлсний дараах гологдол арилгах болон солих тухай албан мэдэгдэл. - Нийлүүлэх бараа нь чанар стандартын шаардлага хангасныг нотлох мэргэжлийн хяналтын байгууллагын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний бичиг, дүгнэлт. - Татварын тодорхойлолтыг e-tax.mta.mn болон Төрийн үйлчилгээний цахим машин (ТҮЦ)-аас авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна .
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: ШШГЕГ-ын харъяа “Хэрэмт цамхаг” УТҮГ 421 дүгээр нээлттэй хорих ангийн хашаанд БЗД-10-р хороо, Амгалан Давхар болон өрөөний дугаар: Санхүүгийн албанын өрөө Огноо: 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Цаг: 12 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: ШШГЕГ-ын харъяа “Хэрэмт цамхаг” УТҮГ 421 дүгээр нээлттэй хорих ангийн хашаанд БЗД-10-р хороо, Амгалан Давхар болон өрөөний дугаар: Хурлын заал. Огноо: 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдөр Цаг: 12 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцаас бүрдэнэ.</p> <p>Шатахуун</p>

Дөрөв.Техникийн тодорхойлолт

“Хэрэмт цамхаг” УТҮГ-т нийлүүлэх шохой нь доорх шаардлагыг хангасан байна.
Үүнд:

1.Шатахууны чанарын үзүүлэлт:

№	Багц нэр	Бүтээгдэхүүний нэр төрөл	Техникийн тодорхойлолт болон стандарт	Сав баглаа боодол
1	Шатахуун	Дизель түлш	MNS 0217:2017	Чанарын шаардлага хангасан ОХУ-с орж ирсэн

2. Чанарын шаардлага: Дээрхи чанарын норм үзүүлэлтийг бүрэн буюу түүнээс дээш хэмжээгээр хангасан байна.

3. Стандарт: MNS 0217:2017 стандартыг хангасан байна.

4. Баглаа боодол: Нийлүүлэгч барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг хариуцах ба холбогдох бусад бичиг баримтыг хүлээлгэн өгнө.

БАРАА НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

№	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Нийлүүлэх эхний хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	Дизель түлш			ШШГЕГ-ын харьяа “Хэрэмт цамхаг” УТҮГ	2020.04.25	2020.12.31

Тав: ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. Нийлүүлэх **шатахуун** нь техникийн тодорхойлтонд заасан тоо хэмжээ, шаардлагыг хангасан байна.
- 1.2. Хэрэмт цамхаг” УТҮГ-ын захирлын тушаалд томилогдсон байнгын комиссоор шалгуулж хүлээлгэн өгнө.
- 1.3. Бараа нь үйлдвэрлэгчийн шалгаж туршсан баталгаа сертификаттай мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр баталгаажуулсан байна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг хэрэглэх явцад гарсан гологдлыг тухай бүр шинэчлэн сольж өгнө.
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 2.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Захиалагч Монгол Улсын гаднаас санал болгосон барааны төлбөрийг нийлүүлэгчид дараах журмын дагуухийнэ.
1. **Урьдчилгаа төлбөр:** Байхгүй
 2. **Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:** Байхгүй.
 3. **Барааг хүлээн авахад төлөх төлбөр: 100 хувь /**
Барааны төлбөрийг гүйцэтгэлээр нь буюу бараа хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийг хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹**
- 4.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн 7 хоног тутамд 0,5%
Алдангийн нийт дүн: 10% иас хэтрэхгүй байна.

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/ гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]